



2025

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ АЖЛУУД, ЗАХ ЗЭЭЛИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

01	ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД	03
02	2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	07
	ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВЬЦААНЫ	09
	АРИЛЖАА	10
	БУСАД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА УУБ-НИЙ	11
	АРИЛЖАА	12
03	БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ	15
04	САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	16
05	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ	19
	НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА ХУВЬЦААНЫ	20
	МЭДЭЭЛЭЛ	21

01 | ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧЭЭР Б.ДӨЛГӨӨН ТОМИЛОГДОВ
2025-01-17

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №2 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаярыг чөлөөлж, Б.Дөлгөөнийг томиллоо.



ЭНЭТХЭГИЙН ЭЛЧИН САЙД НОЁН АТУЛ МАЛХАРИ ГОТСУРВЭГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ
2025-02-12

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн "Энэтхэгийн элчин сайд Атул Малхари Готсурвэг хүлээн авч уулзан, хоёр орны хөрөнгийн биржүүдийн хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ. Мөн цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, УУБ-ний хоёрдогч зах зээлийн арилжаанд Энэтхэг компаниуд оролцох боломжийг судлах чиглэлд ажиллахаар тохиролцсон юм.

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЖУРАМ"-ЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ДАГАЖ МӨРДҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЛӨӨ

2025-03-19

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.10, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ТУЗ-ийн 2025.03.11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан "Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-ыг үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 75 дугаар тогтоолоор зөвшөөрлөө.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫГ ДАГАЖ МӨРДҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЛӨӨ

2025-03-19


Санхүүгийн зохицуулах хороо нь 2025.03.18-ны өдрийн 76 дугаар тогтоолоор "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-ыг тус тус 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхийг зөвшөөрсөн.

Түүнчлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ТУЗ-ийн 16 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам", "Зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам", "Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам", "Хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-уудыг тус тус үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхийг зөвшөөрсөн юм.

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН УДИРДЛАГУУД ГАШУУН СУХАЙТ БООМТОД АЖИЛЛАЛАА

2025-03-24

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Сангийн сайд Б.Жавхлангаар ахлуулсан Богино хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг (2025-03-21) Дорноговь аймгийн Ханги, Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтуудад ажилласан. Энэ үеэ биржийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн, УУБАГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсанаа нар Гашуун сухайт боомтод ажиллан, хилийн бүс дэх уул уурхайн экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлт, татан авалт, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл байдалтай танилцсан юм.



01 | ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАНИЛЦУУЛАХ ӨРГӨТГӨСӨН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-03-27

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь УУБА-г идэвхжүүлэх зорилгоор шинэчлэн баталсан журмуудын өөрчлөлтөөр бий болж буй боломж, давуу талуудыг төр, хувийн хэвшил байгууллагууд болон гадаадын худалдан авагч компаниудад дэлгэрэнгүй танилцуулсан бөгөөд УУБА-ны цаашдын чиг хандлагын талаар санал солилцох өргөтгөсөн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны журамд өөрчлөлт оруулахдаа арилжаанд оролцогч талуудад харилцан ашигтай байх зарчмыг баримтлан өөрчлөлтүүдийг оруулсан” гэдгийг онцолсон.

“ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ”-ЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАМЖИЛЛАА

2025-04-01

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Гшүүнчлэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг батламжиллаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ НЭЭЛТТЭЙ АРИЛЖАА 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДРӨӨС ЭХЭЛЛЭЭ

2025-04-02

Сангийн яам нь Засгийн газрын дунд хугацааны өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, санхүүгийн зах зээлд төгрөгийн бондын суурь хүүг тогтоох зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлүүлэхээр болсон.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Сангийн сайдын 2025 оны 51 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны 2025 оны 2 дугаар улирлын арилжааны хуваарь”-ийн дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим арилжааны систем www.bond.mse.mn-ээр дамжуулан зохион байгуулж байна.



“БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ), ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-04-03

Монголын хөрөнгийн бирж” ХК, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорацтай хамтран (2025.04.03) биржид бүртгэлтэй компаниудад зориулсан “Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), тогтвортой байдлын тайлагнал” сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа.

2024 оны 10-р сард тус журамд өөрчлөлт орсонтой холбоотойгоор харилцагч байгууллагуудад БОНЗ-ын тайлан гаргах арга аргачлал, сайн жишиг, туршлагын талаар мэдээлэл хүргэх зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгуулсан юм. Сургалтад нийт 30 компанийн 50 гаруй төлөөлөл оролцлоо.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫГ 4, 5, 6 ДУГААР САРУУДАД ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-04-14

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2025 оны 4, 5, 6 дугаар саруудад уламжлал ёсоор “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт”-ыг танхимаар зохион байгуулсан. Цаашид сонирхсон иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч цахимаар суралцах боломжтой болох ба орчин үеийн технологитой уялдуулан бэлтгэл ажлыг хангаж, танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

01 | ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК, МҮХАҮТ, МҮЦАЭХ-НЫ УДИРДЛАГУУД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

2025-04-17

Монгол Улсын Их Хурлын даргын санаачилгаар зохион байгуулагдсан “Бонд форум-2025” арга хэмжээний үеэр Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, МҮХАҮТ болон МҮЦАЭХ-ны удирдлагууд үндэсний ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон үнэт цаас гаргахад хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЛАА

2025-04-18

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2022 онд IPO хийж, 34 хувиа олон нийтэд нээлттэй арилжсан бөгөөд ТУЗ-ийн 2025.02.14-ний өдрийн 04 дүгээр тогтоолын дагуу 2025.04.17-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулж татварын дараах 5,315,705,427.90 төгрөгийг 9,635 хувьцаа эзэмшигчийн дансанд байршууллаа. Мөн компанийн 66% эзэмшигч Сангийн яам буюу улсын төсөвт 10,871,378,992.00 төгрөгийн ногдол ашгийг шилжүүлсэн юм.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙГ НЭЭЛЭЭ

2025-04-23

“Монголын хөрөнгийн бирж” ХКөөрийн байранд “Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн төв”-ийг нээлээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК 2022 онд хувьцаат компанийн хэлбэрт шилжихдээ нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн төвийг байгуулахад зориулж тодорхой төсвийг тусган, тус төлөвлөгөөний дагуу барилгын их засварын ажлыг эхлүүлж, энэхүү төвийг байгуулах, биржийн тохижилт, үйлчилгээний зориулалтыг өргөтгөх ажлыг хийж хэрэгжүүллээ.



ОЮУТНУУД “САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ” МЭДЛЭГ ТҮГЭЭХ ӨДӨРЛӨГТ ХАМРАГДАН, БИРЖИД ЗОЧЛОВ

2025-04-23

Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, Хадгаламжийн даатгалын корпораци болон “Үнэт санхүүгийн нэгдэл” ХХК, Монголын даатгалын холбоо зэрэг хөрөнгийн зах зээлийн зохицуулагч, оролцогч байгууллагууд хамтран “Санхүүгийн зах зээл” мэдлэг түгээх өдөрлөгийг 2025 оны 4 дүгээр сард зохион байгуулсан. Тус өдөрлөгийг СЭЗИС, МУИС, СИТИ их сургуулиудад зохион байгуулж, оюутнууд Санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагуудтай танилцах аялалд хамрагдсанаар өндөрлөсөн юм.

01 | ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН УДИРДЛАГА БНХАУ-ЫН КОКСЖИХ НҮҮРС, КОКСЫН ХУДАЛДАН АВАЛТЫН 12 ДАХЬ ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ

2025-05-16

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн 2025 оны 5 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд БНХАУ-ын Сычуан мужийн Чэндү хотноо зохион байгуулагдсан БНХАУ-ын баруун урд бүс нутгийн коксжих нүүрс, коксын зах зээлийн 12 дахь удаагийн уулзалтад оролцлоо



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН БОЛОН “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН УДИРДЛАГУУД УУБ-НИЙ ХУДАЛДАН АВАГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

2025-05-20

Сангийн сайд Б.Жавхлан болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн зарим удирдлагууд (2025.05.20) уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны гол худалдан авагч төр, хувийн компанийн төлөөллүүдийг хүлээн авч уулзсан.

Оролцогчдын зүгээс нүүрсний үнийн уналт, тодорхойгүй байдлын улмаас худалдан авагдах үүссэн хүндрэлийн талаар танилцуулж, талууд биржийн арилжааг идэвхжүүлэх боломжийн талаар харилцан санал солилцсон юм.



“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА 1072 ХУВЬЦАА” НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-05-24

“Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” нээлттэй өдөрлөгийг Улаанбаатар хот болон Дундговь, Өмнөговь аймагт зохион байгууллаа. Өдөрлөгт Санхүүгийн зохицуулах хороо, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Голомт капитал” ҮЦК” ХХК, “ТиДиБи секьюритис ҮЦК” ХХК, “Өлзий энд Ко ҮЦК” ХХК, “Алекс капитал ҮЦК” ХХК, “Үнэт секьюритис ҮЦК” ХХК, “Новел инвестмент ҮЦК” ХХК, “Эс Жи Инвестмент энд Секьюритис ҮЦК” ХХК, Би Ди Сек ҮЦК” ХК, “Гүүдсек ҮЦК” ХХК нар оролцож нийт 1000 гаруй иргэн, 30 гаруй ААН-үүдэд сургалт зөвлөгөө мэдээлэл өгсөн.




БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХӨРВӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-06-10


Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн удирдлагууд (2025.06.10) биржийн 2, 3 дугаар ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниудын гүйцэтгэх захирал болон, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдтэй уулзалт хийсэн.

Тус уулзалтаар хувьцаат компаниудын хувьцааны төвлөрөл, хууль, журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар хэлэлцэж, биржийн зүгээс жил жилийн санхүүгийн үзүүлэлт, тайлагналд дүн шинжилгээ хийсэн тойм мэдээллүүд, хойшид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн юм.

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НИЙТ АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН
ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД




= 8 ТЭРБУМ ₮

Өдрийн дундаж арилжааны хэмжээ:
/Үнэт цаас, Уул уурхай/

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ:


НИЙТ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ӨМНӨХ ОНЫ
МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 849.39 ТЭРБУМ
ТӨГРӨГ БҮЮУ 7.53 ХУВИАР ӨСЧ, 12 их наяд
134 ТЭРБУМ ТӨГРӨГ БОЛСОН БАЙНА.



ТОП-20 ИНДЕКС:

ДЭЭД ҮЗҮҮЛЭЛТ 54 018.32 НЭГЖ,
ДООД ҮЗҮҮЛЭЛТ 46 334.87 НЭГЖ,
ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ 50 271.15 НЭГЖ

ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД
7,486.0 НЭГЖЭЭР БҮЮУ 10.95 ХУВИАР
ӨСЧ, 49,246.17 НЭГЖ БОЛСОН БАЙНА.



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



"ТЖТБ" ХХК
"GREEN RECYCLE" ТРАНЧ 2
ӨРИЙН ХЭРЭГСЭЛ

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
40,000.00	13,683,680,000.00₮
	/\$4,000,000/

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ТОО: 20



"БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК
"Бид" 2.0
ӨРИЙН ХЭРЭГСЭЛ

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	10,000,000,000.00₮

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ТОО: 109



"ОМНИ АССЕТ ХОЁР ТЗК" ХХК
ОМНИ АССЕТ2 ХБҮЦ
ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
140,000.00	14,000,000,000.00₮

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ТОО: 76



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЗАСГИЙН
ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС ЗГДҮЦ

2025.04.16-НЫ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,776,257,853.84₮

2025.04.30-НЫ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,573,466,354.01₮



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЗАСГИЙН
ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС ЗГДҮЦ

2025.05.14-НИЙ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,779,554,321.97₮

2025.05.28-НЫ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,774,850,288.94₮

2025.06.10-НЫ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,781,301,670.62₮

2025.06.25-НЫ АРИЛЖАА

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

ТОО ШИРХЭГ:	ҮНИЙН ДҮН:
100,000.00	9,575,672,270.34₮

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



143

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНЭТ
ЦААС АРИЛЖИГДСАН



110.8

ТЭРБУМ ₮

АРИЛЖИГДСАН ХУВЬЦААНЫ НИЙТ
ҮНИЙН ДҮН

74.16

ТЭРБУМ ₮

ЭНГИЙН АРИЛЖАА

36.72

ТЭРБУМ ₮

БАГЦЫН АРИЛЖАА

143 ХК-ИЙН ҮНЭТ ЦААС АРИЛЖИГДСАНААС:

↑ 50

ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХАНШ ӨССӨН

↓ 85

ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХАНШ БУУРЧ

= 8

ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХАНШ ТОГТВОРТОЙ

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ТОП 5 ХУВЬЦАА

ҮНИЙН ДҮНГЭЭР

ХААН БАНК	MSE: KHAN	19.95 ТЭРБУМ ₮
МАНДАЛ ДААТГАЛ	MSE: MNDL	19.32 ТЭРБУМ ₮
ИНВЕСКОР ББСБ ИННОВЭЙШН	MSE: INV	9.39 ТЭРБУМ ₮
ИНВЕСТМЕНТ	MSE: QPAY	7.33 ТЭРБУМ ₮
ГОЛОМТ БАНК	MSE: GLMT	5.25 ТЭРБУМ ₮

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ТОП 5 ХУВЬЦАА

		2024.06.27	2025.06.30	
COP	MSE: SOR	812₮	→ 9,500₮	↑ 1,069.95%
ХАРХОРИН	MSE: HHN	1,360₮	→ 8,000₮	↑ 488.24%
ОРХОН ХӨГЖИЛ	MSE: HJL	434.89₮	→ 1,527₮	↑ 251.17%
УЛААНСАН	MSE: UNS	4,072₮	→ 13,900₮	↑ 241.36%
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН	MSE: ERDN	1,099₮	→ 2,555₮	↑ 132.48%

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА



ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД **64.37 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ **745.36 МЯНГАН ШИРХЭГ** 6 ТӨРЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС АРИЛЖСАН БАЙНА.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА



ТАЙЛАН ХУГАЦААНД **"ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН"** БОЛОН **"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ"** ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГААР **4.24 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ **5.22 СЯ ШИРХЭГ** НЭГЖ ЭРХИЙГ АРИЛЖСАН БАЙНА. **"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ"** ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НИЙТ 2.99 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ 2.14 СЯ ШИРХЭГ НЭГЖ ЭРХ БАГЦЫН АРИЛЖААГААР АРИЛЖИГДСАН БАЙНА.

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА



ТАЙЛАНТ ХУГАЦААНД ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГААР **23.68 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ **140 МЯНГАН ШИРХЭГ** ӨРИЙН ХЭРЭГСЭЛ АРИЛЖСАН БӨГӨӨД ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНГИЙН 27.3 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ СТАТИСТИК

НИЙТ АРИЛЖАА:	494	УДААГИЙН ЦАХИМ ДУУДЛАГА АРИЛЖАА
НИЙТ ДҮН:	5.3	САЯ ТОНН БҮТЭЭГДЭХҮҮН
	1.4	ИХ НАЯД ₮

АРИЛЖААНД ОРОЛЦСОН КОМПАНИУД:

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК	ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС ТӨҮГ
ТАВАНТОЛГОЙ ХК	ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ХХК
ЭНЕРЖИ РЕСУРС ХХК	ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН ХХК
ХАНГАД ЭКСПЛОРЭЙШН ХХК	ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ
АНДЫН ИЛЧ ХХК	




График 1 2025 оны эхний хагас жилийн уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээнд эзлэх хувь.

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА

НҮҮРСНИЙ АРИЛЖАА



АРИЛЖААНЫ ТОО:

55 УДАА



ХЭМЖЭЭ:

2.33 САЯ ТОНН



ДҮН:

610.19 ТЭРБУМ ₮



ДУНДАЖ ҮНИЙН ӨСӨЛТ:

6.47%



НЭМЭЛТ ОРЛОГО:

4.7 ТЭРБУМ ₮



ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА



АРИЛЖААНЫ ТОО:

109 УДАА



ХЭМЖЭЭ:

2.96 САЯ ТОНН



ДҮН:

630.51 ТЭРБУМ ₮



ДУНДАЖ ҮНИЙН ӨСӨЛТ:

4.33%



НЭМЭЛТ ОРЛОГО:

14.24 ТЭРБУМ ₮



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХАМГИЙН ИХ АРИЛЖИГДСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ

1/3 КОКСЖИХ – 33.08%

201.86

ТЭРБУМ ₮

ДЭГДЭМХИЙ БОДИС ДУНД – 24.74%

150.97

ТЭРБУМ ₮

БАЯЖУУЛСАН КОКСЖИХ – 18.39%

112.23

ТЭРБУМ ₮

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА

ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖАА



КОМПАНИ:

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР



ХЭМЖЭЭ:

20,000 ТОНН



ДҮН:

139.53 ТЭРБУМ ₮



ДУНДАЖ ҮНИЙН ӨСӨЛТ:

2.44%



НЭМЭЛТ ОРЛОГО:

2.51 ТЭРБУМ ₮

ХАЙЛУУР ЖОНШНЫ АРИЛЖАА



АРИЛЖААНЫ ТОО:

6 УДАА



ХЭМЖЭЭ:

18,265 ТОНН



ДҮН:

17.35 ТЭРБУМ ₮



ДУНДАЖ ҮНИЙН ӨСӨЛТ:

17.09%



НЭМЭЛТ ОРЛОГО:

518.35 сая ₮



ХУДАЛДАГЧИД:

ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС ТӨҮГ

13.3 МЯН.ТН / 15.6 ТЭРБУМ ₮

ОЧИР МАНДАЛ ХАЙРХАН

5.0 МЯН.ТН / 1.7 ТЭРБУМ ₮

03 | БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ



ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

68.41% НЬ ЗОХИХ ТҮВШИНД БУЮУ
ХАНГАЛТТАЙ



НОГДОЛ АШИГ ТАРААЛТ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

ӨМНӨХ ОНООС 41%-
ИАР ӨССӨН

45 ХУВЬЦААТ КОМПАНИ
1,264.02 ТЭРБУМ ТӨГРӨГ



БҮРТГЭЛЭЭС ХАССАН

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСД
БҮРТГЭЛЭЭС ХАССАН НИЙТ 8
КОМПАНИ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




ОРЛОГО, ЗАРДЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мянган төгрөг				
Д/д	Орлогын үзүүлэлт	2024 Q2 гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 Q2 гүйцэтгэл
1	Үнэт цаасны арилжааны шимтгэл	1,694,275	3,520,887	803,589
2	УУББ-ийн арилжааны шимтгэл	5,589,562	6,008,889	1,251,591
3	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	1,195,601	1,421,485	999,962
4	Хүүгийн орлого	15,286,084	31,406,008	14,697,997
5	Бусад үйл ажиллагааны орлого	178,422	336,020	160,533
	ДҮН	23,943,944	42,693,289	17,913,672
Д/д	Зардлын үзүүлэлт	2024 Q2 гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 Q2 гүйцэтгэл
1	Цалин хөлс + НДШ	1,636,950	5,010,713	2,258,854
2	Үндсэн хөрөнгийн элэгдэл	337,838	978,182	380,402
3	Систем ашиглалтын жилийн зардал	500,596	1,036,324	523,113
4	Систем ашиглалтын элэгдлийн зардал	342,168	684,336	342,168
5	Зохицуулах үйлчилгээний хөлс /СЗХ/	655,312	860,328	205,025
6	Бусад үйл ажиллагааны зардал	456,252	2,515,650	724,901
	ДҮН	3,929,116	11,085,533	4,434,463

ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА

Сая төгрөгөөр



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД МХБ-ИЙН ХУВЬЦААНЫ ХАНШ ОНЫ ЭХНЭЭС **₮89.42 БУЮУ 25.20 ХУВИАР БУУРЧ**, НЭГЖ ХУВЬЦАА **265.48 ТӨГРӨГТ** ХҮРЧ ХААГДСАН БАЙНА.

- НИЙТ АРИЛЖИГДСАН ШИРХЭГ: **15,672,703**
- НИЙТ АРИЛЖИГДСАН ҮНИЙН ДҮН: **₮4,800,960,287.59**

P/E ХАРЬЦАА

7.57

P/B ХАРЬЦАА

1.3

ROA ХАРЬЦАА

1.41%

ROE ХАРЬЦАА

17.15%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО


2025 он

9,980

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



МХБ-ИЙН ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ /MSE/





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 21

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор шаардлагатай материалыг боловсруулж, цуглуулж, хууль болон журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж **2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 10:00 цагт** танхим болон цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн саналын эрхтэй нийт 350,463,539 ширхэг хувьцаанаас 68.76 хувь буюу 240,991,242 ширхэг хувьцаа эзэмшиж буй **64 хувьцаа эзэмшигч оролцож**, ирц баталгаажсан.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлах;
3. Компанийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг системийн талаар авах зарим арга хэмжээний тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох тухай;
5. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК НЬ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЭЖ “АРЧЛАХГҮЙ БОЛ УРГАХГҮЙ” УРИАН ДОР ХАВРЫН БҮХ НИЙТИЙН МОД ТАРИЛТЫН ӨДӨР “ОЛОН УЛСЫН ЭКО ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”-ИЙН ТАЛБАЙД ШАР ХУАЙС, НАРС ЗЭРЭГ МОД СУУЛГАЖ АНХНЫ УСАЛГАА, АРЧИЛГААГ ХИЙЛЭЭ. БИД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ЖИЛ БҮР МОД ТАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛЖУУЛАХ ЗОРИЛТ ТАВИН АЖИЛЛАЖ БАЙНА.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК
СҮХБААТАРЫН ТАЛБАЙ 3, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС
УТАС: (976)-11-313 747
ВЕБ ХУУДАС: WWW.MSE.MN